# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
# ЯАМНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАН, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
# ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.МӨНХСАРНАЙГИЙН
# 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх ажлыг зохицуулах, шийдвэрлэлтэд хяналт тавих, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг яамны хэмжээнд хангаж ажиллана. | Шийдвэрлэлтийн дундаж хоногийг 13,7%-иар бууруулах | Шийдвэрлэлтийн дундаж 29 хоног, 21 цаг, 32 минут | Шийдвэрлэлтийн дундаж 25 хоног | 1.Иргэдээс тус яам болон албан тушаалтанд хандан нийт 65 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна. Иргэд олон нийттэй харилцах төв 11-11-ээс ирүүлсэн 30, байгууллага бүртгэсэн 35 өргөдөл, гомдол, санал, хүсэлт. /Өмнөх оны 12 сард ирсэн 10 өргөдөл, гомдлыг 2025 онд шийдвэрлэсэн/<br>Нийт 65 өргөдөл, гомдол ирүүлснээс хугацаандаа байгаа 20, хугацаа хэтэрсэн 6, шийдвэрлэсэн 39. Шийдвэрлэлтийн дундаж 31 хоног, 13 цаг, 14 минут | 01 | 06 |
| 2. | Арга хэмжээ 1.2. Харьяа байгууллагуудаас өргөдөл, гомдлын тайланг улирал бүр авч нэгтгэн шийдвэрлэлтийн үр дүнг яамны удирдлагуудад танилцуулж, нэгдсэн тайлан, мэдээг Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлнэ. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 4 | 2 | Яам болон харьяа 6 байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны 1 дүгээр улирлын тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 02/819 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2025 оны эхний хагас жилийн тайлан 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор нэгтгэн гаргана. | 01 | 06 |
| **Зорилт 2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 2.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын цахим хөгжил, харилцаа холбооны салбарт хамаарах заалтын хэрэгжилтийг нэгтгэн заасан хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ. | Нэгтгэсэн тайлангийн тоо | 1 | - | Хугацаа болоогүй.<br>Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хавсралтаар батлагдсан тайлагнах цаглабарын дагуу 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэх өөрчлөлт орсон. | 01 | 10 |
| 4. | Арга хэмжээ 2.2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний цахим хөгжил, харилцаа холбооны салбарт хамаарах заалтын хэрэгжилтийг нэгтгэн заасан хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ. | Нэгтгэсэн тайлангийн тоо | 12 | 5 | Хугацаа болоогүй.<br>Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хавсралтаар батлагдсан тайлагнах цаглабарын дагуу 2025 оны 07 дугаар сард тайлагнахаар өөрчлөлт орсон. | 01 | 07 |
| 5. | Арга хэмжээ 2.3. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн цахим хөгжил, харилцаа холбооны салбарт хамаарах заалтын хэрэгжилтийг нэгтгэн заасан хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ. | Нэгтгэсэн тайлангийн тоо | 1 | - | Хугацаа болоогүй.<br>Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хавсралтаар батлагдсан тайлагнах цаглабарын дагуу 2026 оны 01 дүгээр сарын 1-ний өдрийн дотор тайлагнахаар өөрчлөгдсөн. | 01 | 07 |
| 6. | Арга хэмжээ 2.4. Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн заасан хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ. | Нэгтгэсэн тайлангийн тоо | 7 | 1 | Хугацаа болоогүй.<br>Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хавсралтаар батлагдсан тайлагнах цаглабарын дагуу 2025 оны 07 дугаар сард тайлагнахаар өөрчлөгдсөн. | 01 | 07 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Арга хэмжээ 2.5. Төрийн захиргааны удирдлагын газрын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулна. | Боловсруулсан төлөвлөгөөний тоо | 1 | 1 | Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулсан. Газар, хэлтсүүдийн батлагдсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө /11/-г архивын нэгж болгон хадгалж байна. | 01 | 01 |
| 8. | Арга хэмжээ 2.6. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Төрийн захиргааны удирдлагын газрын төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэнэ. | Нэгтгэсэн тайлангийн тоо | 2 | 2 | Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн биелэлтийг 06 дугаар сарын 13-ны өдөр, Төрийн захиргааны удирдлагын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 06 дугаар сарын 12-ны өдөр нэгтгэн гаргаж, удирдлагад танилцуулсан. | 06 | 06 |
| 9. | Арга хэмжээ 2.7. Яамны сар бүрийн үйл ажиллагааны товч тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ. | Хүргүүлсэн тайлангийн тоо | 12 | 5 | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2025 оны 1-5 дугаар сарын үйл ажиллагааны товч тайланг сар бүр нэгтгэн Төрийн мэдээллийн сүлжээний цахим систем (www.unelgee.gov.mn)-д оруулж, тайлагнасан. | 01 | 06 |
| 10. | Арга хэмжээ 2.8. Сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, гэрээний биелэлтийн тайланг нэгтгэн, үр дүнг хагас, бүтэн жилээр дүгнүүлэх ажлыг зохион байгуулна. | Байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо<br>Биелэлтийг дүгнүүлэх ажлын тоо | 5<br><br>2 | 5<br><br>2 | Харьяа байгууллага болох И-Монгол академи УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг, Үндэсний дата төв УТҮГ-ын стратеги төлөвлөгөө /2025-2028/-г Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд баталсан. Тайлан тайлагнах хугацаа болоогүй байна. | 01 | 06 |
| 11. | Арга хэмжээ 2.9. Аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулж, албажуулах, гэрээний биелэлтийг нэгтгэн хагас болон бүтэн жилээр дүгнүүлэх ажлыг зохион байгуулна. | Гэрээ болон төлөвлөгөөний тоо<br>Гэрээний биелэлтийн тоо | 22<br><br>22 | 22<br><br>22 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан. | 01 | 06 |
| **Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.** | | | | | | | |
| 12. | Арга хэмжээ 3.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу | Албан бичиг хүргүүлсэн, | 1<br>Нэгжийн тоо-23 | 1<br>1 | Яамны архивт 2024 оны 12 дугаар сарын явсан бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, өргөдөл гомдолтой холбоотой | 01 | 06 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан бичиг боловсруулах, шийдвэрлэх, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг архивт хүлээлгэн өгнө. | шийдвэрлэсэн эсэх<br>Архивт өгсөн эсэх<br>Тийм-1, Үгүй-0 | | | 2025 оны явсан бичиг, төслийг эмхлэн цэгцэлт архивлан 42 хадгаламжийн нэгжийг архивт хүлээлгэн өгсөн.<br><br>2025 онд 13 бичиг явуулж, 39 ирсэн бичгийг шийдвэрлэсэн. | | |
| 13. | Арга хэмжээ 3.2. Албан чиг үүргийн дагуу удирдлагаас шилжүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ. | Хугацаанд нь шийдвэрлэсэн эсэх<br>Тийм-1, Үгүй-0 | 1 | 1 | Тайлант хугацаанд удирдлагаас шилжүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт байхгүй болно. | 01 | 06 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэнду уссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын тушаалаар Архив-бичиг хэргийн албан үүргийг хавсран гүйцэтгэх | - | - | - | Архив-бичиг хэргийн албан үүргийг 6 сар хугацаанд хавсран гүйцэтгэсэн. Хавсран гүйцэтгэх хугацааны явсан бичгийн архивлан 42 хадгаламжийн нэгж архивт хүлээлгэн өгсөн. | 2024.12.02<br>-<br>2025.06.02 | 100 |
| 2 | Үндэсний бичгийн хэвлэмэл хуудас хэвлүүлэх, 2025 онд хэрэглэгдэх хэвлэмэл хуудсыг захиалах | - | - | - | Монгол хэлний тухай хуулийн дагуу төрийн албан хэргийг хос бичиг (кирилл болон үндэсний)-ээр хөтлөн явуулж байгаатай холбогдуулан хэвлэмэл хуудасны эх загварыг кирилл болон үндэсний бичгээр хянан баталгаажуулж, хэвлүүлэх хүсэлтийг Архивын ерөнхий газарт 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 03/15 дугаартай албан бичгээр хүргүүлж, үндэсний бичгээ р27 нэр төрлийн хэвлэмэл хуудас баталгаажуулж, 2025 онд хэрэглэгдэх үндэсний бичгийн хэвлэмэл хуудас A4-5160, A5-1040, кирилл бичиг A4-2740 ширхэг хэвлүүлж, хүлээн авсан. | 2024.12.25<br>-<br>2025.01.10 | 100 |
| 3 | Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтад санал | | | | Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар баталсан "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын | 2025.04.18<br>-<br>2025.05.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авч, Архивын ерөнхий газарт санал хүргүүлэх | | | | жагсаалт"-д нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаатай холбогдуулан харьяа, салбар байгууллагуудад 2025 оны 04 дүгээр сарын 18-ны 02/890 дугаартай албан бичгээр санал авч, Архивын ерөнхий газарт 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт"-д тусгах саналаа цахим шуудан /unurtuya@archives.gov.mn/-аар хүргүүлсэн. | | |
| 4 | Хэвлэмэл хуудасны нэр төрөл, индекс батлуулах | | | | "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан бичиг баталгаажуулан илгээх албан тушаалтны индекс", "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжид олгох хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын индекс", "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хэвлэмэл хуудаст үйлдэх баримт бичгийн нэр төрөл, индекс, хариуцах албан тушаалтан", "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны нэгжийн дотоод албан бичигт илгээх албан тушаалтны индекс"-ийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар тус тус батлуулсан. | 2025.03.12<br>-<br>2025.03.17 | 100 |
| 5 | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны А/187 дугаар тушаалаар 2024 оны 6 сарын ирсэн, явсан бичиг архивлах | | | | 2024 оны ирсэн, явсан бичгиийг эмхлэн цэгцэлж, архивлан архивт 2024 оны 3, 7, 8, 9, 10 дугаар сарын нийт 79 архивын нэгж, 2025 оны 1-5 сарын явсан бичиг 42 хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгсөн. | 2025.06.03<br>-<br>2025.06.10 | 100 |
| 6 | Цагаан сарын баярын хариуцлагатай жижүүр ажиллуулах тушаал боловсруулах, харьяа, салбар байгууллагад мэдэгдэх | | | | Цагаан сарын баяраар хариуцлагатай жижүүрээр ажиллуулах талаар тушаалын төсөл, удирдамжийг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны | 2025.02.26<br>-<br>2025.03.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 02 дугаар сарын 26-ны өдрийн А/47 дугаар тушаалаар батлуулсан. Монгол үндэстний уламжлалт баяр Цагаан сар билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 2, 3-ны өдрүүд болон бүх нийтээр амрахаар тогтоосон 2025 оны 03 дугаар сарын 01-ээс 05-ны өдрүүдэд тус яамны байранд хариуцлагатай жижүүрээр ажиллах албан хаагчдын мэдээллийг харьяа, салбар байгууллагуудад 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 03/482 дугаартай албан бичгээр хүргүүлж, тус байгууллагуудын хариуцлагатай жижүүрийн хуваарийг авч, 2025 оны 03 дугаар сарын 01-ний хариуцлагатай жижүүрээр ажилласан. Мөн цагаан сарын баярын амралтыг тус яам болон харьяа байгууллагууд нөхөн ажиллуулах хуваарийг Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. | | |
| 7 | Сайдын шуурхайн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу цахим албан хэрэг хөтлөлтийг эрчимжүүлэх, мэдээлэл хүргүүлэх | | | | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэл, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны харьяа болон салбар байгууллагууд тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, Албан бичиг солилцооны дундын систем ашиглан баримт бичиг цахим хэлбэрээр солилцох, албан хэрэг хөтлөлтийг цахим шилжилтэд шилжүүлэн ажиллах талаар харьяа, салбар байгууллагуудад 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/590 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Албан бичиг солилцооны дундын | 2025.03.14 - 2025.03.16 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | системийн ашиглалтын талаарх илтгэх хуудсыг удирдлагад танилцуулсан. Харьяа, салбар байгууллагуудаас Монгол шуудан ХК нь цахим системд ашигладаггүй бөгөөд удахгүй нэвтрүүлэх талаар судалж байгаа болно. | | |
| 8 | Сайдын шуурхайн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2025 оны А/59 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангуулах | | | | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/59 дүгээр тушаалаар шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг ханган ажиллах талаар харьяа 3 байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 02/927 дугаартай албан бичгээр мэдээлэл хүргүүлсэн. Тус тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газарт өгсөн 5 үүрэг даалгаврын биелэлтийг гарган танилцуулга бэлдэж, газрын даргад танилцуулсан. | 2025.04.23 - 2025.05.12 | 100 |
| 9 | Монголын цахилгаан холбоо ХК-д хяналт шалгалтын ажлын хэсэгт гишүүнээр ажиллах | | | | Тус байгууллагад 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлттэй холбоотой жагсаалтыг гарган өгч, 2025 оны 02 дугаар сарын 04, 03 дугаар сарын 14, 18, 19-ний өдрүүдэд нийт 94 хуудас бүхий баримт бичгийн хуулбар, 10 файл (5.27MB) бүхий баримт бичиг ирүүлж, түүнд хяналт шалгалт хийж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр ажлын илтгэх хуудсыг хүргүүлсэн. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Монгол Улсын стандартын 2-р хэсэг “Баримт бичгийн | 2025.01.29 - 2025.03.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрдэл, тэдгээрт тавих шаардлага MNS5140-2:2021", Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар баталсан Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын хүрээнд ажиллалаа. | | |
| 10 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2024 онд салбарын эрхлэх асуудлын хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээний тайлан хүргүүлэх, Үндэсний мод тарих өдөр мод тарих, арчлахад оролцох | | | | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2024 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг харьяа, салбар байгууллагуудад 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 02/910 дугаартай албан бичиг хүргүүлж, нэгтгэн Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 02/984 дугаартай албан бичгээр болон цахим шуудангаар тайланг хүргүүлсэн.<br><br>Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Түргэний гол дагуух Ногоон хэрэм" зурваст мод тарих, арчлан хамгаалах арга хэмжээнд оролцож, мод тарьж, арчилсан. | 2025.04.21<br>-<br>2025.04.19 | 100 |
| 11 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2020-2025 оны нэгдүгээр улиралд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, мэдээлэл хүргүүлэх | | | | Холбогдох мэдээллийг бэлтгэн 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр тус байгууллагын албан хаагчид тоон мэдээллийг өгч, тайлангийн товхимолд Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ч.Болор-Эрдэнэ хүргүүлсэн. | 2025.05.19 | 100 |
| 12 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт хүргүүлэх | | | | 1.Тус яамны 2025 оны 1 дүгээр улирлын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр цахим системд тайлагнаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, | 2025.04.01<br>-<br>2025.04.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дотоод аудитын газарт нотлох баримтын хамт хүргүүлсэн.<br><br>2.Ерөнхий сайдын 2025 оны захирамжийн дагаа тус яамны хэрэгжилт хангалтгүй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт болон Ерөнхий сайдын шуурхайн 3 үүрэг даалгаврын биелэлтийг гарган 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар гарган 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр цахим системд тайлагнаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт нотлох баримтын хамт хүргүүлсэн.<br><br>3.УИХ-ын 2024 оны 52 дугаар тогтоолын биелэлтийг нэгтгэн Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газарт 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлсэн. | 2025.05.10<br>-<br>2025.05.14<br><br>2025.05.19 | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.Гадны байгууллага болон дотооддоо зохион байгуулсан сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдсан тоо | - | 1 | Төрийн албан хаагчдын гадаад бодлого, аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, чадваржуулах зорилгоор Гадаад харилцааны яам Аюулгүй байдал судлалын хүрээлэнтэй хамтран ХБНГУ-ын Конрад Аденауэрын сангийн дэмжлэгтэйгээр “Гадаад бодлого, аюулгүй байдлын чадавхжуулах сургалт”-д хамрагдсан. | 2025.05.20-2025.05.24 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2.Төрийн албаны сургууль Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдсан тоо | - | 1 | Төрийн албаны сургууль Удирдлагын академийн Төрийн албан хаагчийг дунд хугацааны давтан сургалтад 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл хугацаанд суралцаж, 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн R2895 дугаартай сертификаттай төгссөн. | 2025.01.28-2025.03.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 3.Дотоод аудитын чиглэлээр сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдсан тоо | - | - | Сангийн яамнаас зохион байгуулсан "Дотоод аудитын үйл ажиллагааны стандарт, арга зүй" сэдэвт сургалтад 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр оролцсон. | 2025.05.30-2025.05.30 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Яамны төлөвлөгөө тайлан, өргөдөл, гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн

............................................ /Д.Мөнхсарнай/

2025 06 12

( Огноо )